



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.21 № 07/627
танай _____-ны № _____-т

Г Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчил нь тогтоосон 179.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцтэй бөгөөд зохистой, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант жилийн орлогоо аккурэл сууриар бүртгээгүй;
- Санхүүгийн тайланд тайлагнагдсан 3,061.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Бусад санхүүгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй мөнгөн хадгаламж 3,430.4 сая төгрөгийг тайланд онд ТУЗ-ийн шийдвэргүйгээр үйл ажиллагаанд зарцуулсан, шинээр 1,500.0 сая төгрөгийн хадгаламж нэмж байршуулсан;
- Тайлант оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон НӨАТ-ын тайлангаарх орлогыг тулган шалгахад 323.1 сая төгрөгийн зөрүүтэй, мөн тайлант онд бүртгэсэн орлогоос 59.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг нотлох баримтгүйгээр орлого бууруулах бичилт хийсэн;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 2,142.1 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын цахилгаан холбоо ХК нь нийт 25,870,276 ширхэг энгийн хувьцаатай, үүнээс 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн Газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг гадаад дотоодын иргэд, хуулийн этгээд эзэмшдэг нээлттэй хувьцаат компани бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгж хувьцааны хаалтын ханш 659.6 төгрөг, зах зээлийн үнэлгээ 17,064.0 сая төгрөг байсан байна.

Монголын цахилгаан холбоо ХК нь нийт хувьцааны 34 хүртэлх хувь буюу 11,249,856 ширхэг хувьцааг нэмж гарган, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу нэмэлт хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах бэлтгэл ажлын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулан ажиллаж байна.

Аудитын гол асуудал

ТУЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2022 оны нийт орлогыг 19,458.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 19,410.7 сая төгрөгөөр, 48.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай байхаар эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан. Гүйцэтгэлээр 18,814.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 18,779.1 сая төгрөгийн зардал гарган, 34.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 79 зорилтын хүрээнд 214 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Z:\Yawsan_Bichig\2023\0315 SNAG-61.Docx